

Гэр Хорооллыг Хөгжүүлэх Сайн Дурын Оролцооны Хүрээ (Төсөл)

Гэр хорооллыг хөгжүүлж, өрхүүдийг хотын дэд бүтцэд холбох

2020 оны 5 дугаар сар

MON 49430: Аймаг, сум хөгжүүлэх Хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ)

Гэр хорооллыг хөгжүүлэх сайн дурын оролцооны хүрээний уг төсөл бичиг нь зээлдэгчийн баримт бичиг юм. Уг баримт бичигт АХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлага, эсвэл ажилтны үзэл бодлыг илэрхийлээгүй бөгөөд урьдчилсан шинж чанартай бичиг баримт болно. Та уг веб хуудсын “ашиглах нөхцөл” хэсэгт анхаарлаа хандуулна уу.

Аливаа улсын хөтөлбөр, стратегийг бэлтгэх, төсөл санхүүжүүлэх, эсвэл уг баримт бичигт заасан тодорхой газар нутаг эсвэл газар зүйн байршлыг онцлох, иш татсан нь Азийн Хөгжлийн Банк нь аливаа газар нутаг, талбайн эрх зүйн эсвэл бусад статусын талаар ямарваа нэгэн шүүлт хийсэн гэсэн үг биш юм.

ВАЛЮТЫН ХАНШ

(2020.04.3-ний өдрийн Монгол Банкны ханшаар, www.mongolbank.mn)

Валютын нэгж	–	Төгрөг (MNT)
MNT 1.00	=	\$0.000366
\$1.00	=	MNT 2,789

ЖИЧ

Уг тайланд "\$" тэмдэгт нь ам.долларыг илэрхийлсэн болно.

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	-	Азийн Хөгжлийн Банк
НӨӨ	-	Нөлөөлөлд өртсөн өрх
АГХБХБГ	-	Аймгийн Газрын Харилцаа, Барилга, Хот байгуулалтын
ГЗГЗЗГ	-	Газар Зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн Газар
АХХҮГ	-	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
АМУЦК	-	МУХБ-ны Ассет Менежмент ҮЦК ХХК
НӨИ	-	Нөлөөлөлд өртсөн иргэн
АТН	-	Аймгийн төслийн нэгж
АСХХОХ	-	Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр
АУБХ	-	Аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
МУХБ	-	Монгол улсын Хөгжлийн Банк
НХС	-	Нарийвчилсан Хэмжилт, судалгаа
ГА	-	Гүйцэтгэгч агентлаг
ХХА	-	Хөндлөнгийн Хяналтын Агентлаг
БОНУТ	-	Байгал орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо
ГАА	-	Гүйцэтгэх Ажлын алба
СЗ	-	Санхүүгийн зуучлал
СЗЗ	-	Санхүүгийн зуучлалын зээл
МУЗГ	-	Монгол улсын засгийн газар
ГБМ	-	Гомдол барагдуулах маягт
ГБМ	-	Гомдол барагдуулах механизм
ХА	-	Хэрэгжүүлэгч Агентлаг
ОУСБ	-	Олон улсын санхүүгийн байгууллага
НИ	-	Нутгийн иргэд
СДТН	-	Сум дундын төслийн нэгж
ЯНАШҮ	-	Ядуурал, нийгмийн анхан шатны үнэлгээ
СДБНШ	-	Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт
ГЧНШ	-	Газар чөлөөлөлт, Нүүлгэн шилжүүлэлт
ГЧНШХ	-	Газар чөлөөлөлт, Нүүлгэн шилжүүлэлтийн хороо
ГЧНШАА	-	ГЧНШ-ийн ажлын алба
ХҮ	-	Хяналт ба үнэлгээ
ОШСЗШ	-	Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам
БХБЯ	-	Барилга, Хот Байгуулалтын Яам
БОАЖЯ	-	Байгаль орчин, Аялал жуулчлалын Яам
СЯ	-	Сангийн Яам
ХХААХҮЯ	-	Хүнс, ХАА, Хөнгөн үйлдвэрийн Яам
ТХН	-	Төсөл хэрэгжүүлэх нэгж

ХУЗ	-	Хөтөлбөрийн Удирдах Зөвлөл
НШЕББ	-	Нүүлгэн шилжүүлэлтийн ерөнхий баримт бичиг
ЗГ	-	Зурвас газар
НШТ	-	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ННУ	-	Нийгмийн нөлөөллийн үнэлгээ
ХБББ	-	АХБ-ны Хамгааллын Бодлогын баримт бичиг, 2009
ТОСК	-	Төрийн Орон Сууцны Корпораци
ТН	-	Техникийн нэгж

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Нөлөөлөлд өртсөн өрх: Төсөл эсвэл түүний аливаа нэг бүрэлдэхүүн хэсгийн нөлөөлөлд сөргөөр өртсөн, нэг дээвэр дор амьдарч, нэг гал тогооноос хооллодог нэг гэр бүлийн бүх хүмүүсийг хэлэх ба үүнд нэг цөм гэр бүл эсвэл хэд хэдэн гэр бүл багтаж болно.

Нөлөөлөлд өртсөн иргэд: Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийн хувьд шилжин байршсан этгээд гэдэгт (i) сайн дурын бус газар чөлөөлөлт, (ii) хуулиар тусгай хамгаалалтад авсан газар болон байгалийн цогцолбор газарт газар ашиглалтад сайн дурын бус хязгаарлалт тогтоосны улмаас бодитоор шилжсэн (шилжин суурьших, амьдарч байсан газраа алдах эсвэл орон байраа алдах) болон эдийн засгийн агуулгаар (газар, хөрөнгөө алдах, өмчийн эзэмшлээ алдах, орлогын эх үүсвэр, амьжиргааны эх үүсвэрээ алдах) улмаас шилжин байршсан иргэдийг хэлнэ.

Баг: Аймгуудын сумдын засаг захиргааны хамгийн жижиг нэгж

Нөхөн олговор: Төсөлтэй холбоотой нөлөөллийн улмаас алдагдсан өмч хөрөнгөний оронд олгох бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах төлбөр.

Эдлэх эрх: Өртөгч иргэдэд учирсан хохирлын төрлөөс хамааран тэдний эдийн засгийн болон нийгмийн өмнөх нөхцөл байдлыг сэргээхэд чиглэсэн нөхөн олговор, орлогыг сэргээн тогтоох, шилжин суурьшихад үзүүлэх дэмжлэг, орлогыг орлуулах, нүүлгэн шилжүүлэх зэрэг арга хэмжээ.

Орлуулах өртөг: Хөдөө аж ахуйн болон амьдрах зориулалттай төрөл бүрийн газар, үр тариа, мод болон бусад зүйлсийн нөхөх олговрыг зах зээлийн тухайн үеийн үнэ ханшаар шударгаар тооцсон үнэлгээ; орон сууц болон бусад байгууламжуудыг барилгын материал, ажиллах хүчний зах зээлийн тухайн үеийн ханшаар дахин барьж байгуулах өртгийг буулгасан барилгын материалын үнийг хасахгүйгээр тооцсон дүнг хэлнэ.

Үндсэн хүн ам: Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг шилжүүлэн байрлуулсан газрын орчимд амьдарч буй иргэд олон нийт

Орлогыг сэргээн тогтоох: Өртөгчдийн орлогын эх үүсвэр болон амьжиргааг нөхөн сэргээх.

Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт: Бүтээн байгуулалтын төслийн улмаас бүрэн болон хэсэгчлэн, байнга болон түр хугацаагаар бодитоор (шилжин суурьших, амьдарч байсан газраа алдах эсвэл орон байраа алдах) болон эдийн засгийн агуулгаар (газар, хөрөнгөө алдах, өмчийн эзэмшлээ алдах, орлогын эх үүсвэр, амьжиргааны эх үүсвэрээ алдах) зэргээс Нөлөөлөлд өртсөн иргэдэд хуучин амьдарч

байсан амьжиргаа, орлого болон өмч хөрөнгөө дахин бий болгох шаардлага тулгарах.

Газар чөлөөлөлт: Иргэн өөрийн газар эзэмших эрхээсээ (i) нийтийн эрх ашгийн зориулалтаар (ii) эсвэл нөхөх олговор авах нөхцөлтэйгээр засгийн газрын аливаа агентлагийн албадлагаар татгалзахад хүрэх үйл явцыг хэлдэг. Тухайн газар нь Өртөгч иргэдийн өмчлөл эсвэл эзэмшилд байж болно.

Газар өмчлөх: Газрын тухай хуулийн 3.1.2-т зааснаар – “газар өмчлөх” гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ. Газрыг Монгол улсын иргэн бүрт нас, хүйс харгалзахгүйгээр 2028.05.01-ний өдрийг хүртэл нэг удаа үнэгүй өмчлөх эрхтэй. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран янз бүр байна. Нийслэл Улаанбаатар хотод болон нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт иргэд 0.07 хүртэл га газрыг өмчлөх эрхтэй бол аймгийн төвүүдэд 0.35 хүртэл га, сумын төв, тосгонд 0.5 хүртэл га газар тус тус өмчлөх эрхтэй. Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээ явуулах үйл ажиллагаанаас (газар тариалангийн, үйлдвэрлэлийн гэх мэт) хамааран янз бүр байх ба одоо эзэмшилд байгаа газрын хэмжээ, бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог дээр үндэслэн шийдэгдэнэ. Аж ахуйн зориулалтаар газар өмчлөх эрх улсаас шууд эсвэл дуудлага худалдаагаар газар худалдан авсанаар үүснэ.

Газар эзэмших: Газрын тухай хуулийн 3.1.3-т зааснаар – “газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ. Газар эзэмших эрхийг зөвхөн монгол улсын иргэн, ААН, байгууллагад олгоно. Тухайн газрын Засаг дарга газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээ олгох шийдвэрийг гаргана. Газрыг 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно. Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна. Аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ үйл ажиллагааны төрлөөс хамаарах бөгөөд улс болон газар эзэмшигчийн хооронд байгуулсан гэрээнд заасан байна. Одоогийн мөрдөгдөж байгаа хуулийн дагуу газар өмчлөгчийн хувиар улс сонирхсон Монгол улсын иргэн, ААН, байгууллагат газар эмэмших эрхийг олгодог. Газар эзэмших эрхийг шилжүүлэх боломжтой бөгөөд барьцаанд тавих боломжтой.

Газар ашиглах: Газрын тухай хуулийн 3.1.3-т зааснаар – “газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг хэлнэ. Газар ашиглах эрхийг Монгол улсын иргэн, ААН, байгууллагууд эсвэл гадаад улс, олон улсын байгууллага, гадаад хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай ААН, гадаад иргэн болон харьяалалгүй хүнд тусгай зориулалт, хугацаа, нөхцөл болон гэрээний дагуу олгох боломжтой. Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ. Газрыг 5 жил хүртэл хугацаагаар гэрээгээр ашиглуулах бөгөөд гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр ашиглуулах талаар шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

Газрын зааг, ашиглах журмыг Монгол улсын Засгийн газар тогтооно. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.

Сэргээн босгох: Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийн үед газар чөлөөлөлтөд хамрагдсан эд хөрөнгийн нөхөн төлбөрөөс бусад АХБ-ны Бодлогын хүрээнд хангагддаг нөхөн төлбөрийн арга хэмжээнүүдийг хэлнэ.

Нүүлгэн шилжүүлэлт: Төслийн нөлөөлөлд өртөгч этгээдийг төслөөс өмнө суурьшиж байсан газраас нь бодитоор нүүлгэн шилжүүлэх.

Сервитут (Хязгаартай ашиглалт): НАА-н шугам сүлжээнд засвар хийх зориулалтаар түр хугацаагаар дайчлан эзэмших, дайран гарах давуу эрх эдлүүлэх зэрэг тусгай зориулалтаар аливаа газрын эзэмшигчээс өөр этгээдэд газрыг хязгаартай ашиглах эрх олгох мөн хавсран үүрэгжүүлэхийг хэлнэ.

Нийгмийн бэлтгэл: Нүүлгэн шилжүүлэлтийг хэрэгжүүлэхэд түүнд өртсөн иргэд ААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор нүүлгэн шилжүүлэлтийн үндсэн шийдвэр гарахаас өмнө тэдэнтэй хэлэлцүүлэг хийх үйл явц.

Түр газар ашиглалтын нөлөөлөл: Барилгын ажил гүйцэтгэхэд зориулан авто замын зурвас газрын хилийн гаднах газрыг түр ашиглах тохиолдолд газраа түр хугацаагаар алдах, түүн дээрх барилга байгууламж эд хөрөнгөд хохирол учрах, амьдралын болон бизнесийн хэвийн үйл ажиллагаа доголдох хэлбэрээр иргэн аж ахуйн нэгжүүдэд учрах хохирлыг төлөхөд нөхөн олговор олгох болон нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага бүхий нөлөөлөл.

Узуфрукт: Гэрээ буюу хуулийн дагуу тодорхой хугацаанд өөр этгээдийн зэмшилд байгаа эд хөрөнгийг түүнээс гарах үр шимтэй нь хамт тухайн эд юмсын мөн чанарыг алдагдуулахгүйгээр ашиглах эрх.

Эмзэг бүлэг: Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллөөр илүү хохирох магадлалтай тодорхой бүлэг хүмүүс (ядуу иргэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд).

ГАРЧИГ

I.	ТАНИЛЦУУЛГА	7
A.	АСБХХОХ-ийн мэдээлэл	7
B.	Төсөл 1, 1-р шат	8
C.	Аймгуудад гэр хорооллын загвар гудамжийг хөгжүүлэх	8
II.	ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, МЕХАНИЗМ	12
A.	Зорилт	12
B.	Монгол Улсын хууль ба дүрэм	12
C.	Гэр хорооллын хөгжлийг хэрэгжүүлэх гол алхмууд	13
D.	Хэрэгжүүлэх алхмууд	13
E.	Газар өмчлөгчдөд олгох сонголтууд	17
F.	Газар эзэмших эрхгүй газар эзэмшигчид олгох сонголт	18
G.	Гэр хороолол хөгжүүлэлтийн нийтлэг хувилбарууд	18
H.	Загвар гудамж хөгжүүлэх төслийн хүрээнд төсөлд оролцогчдоос авсан газрын ашиглалт	21
III.	НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ	22
IV.	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ОРОЛЦОО	23
V.	БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ	26
VI.	ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ	27
VII.	ХЯНАЛТ БА ҮНЭЛГЭЭ	29
VIII.	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	31
	ХАВСРАЛТ А. ТЕХНИКИЙН НЭГЖ – КОНСЕПЦ, ХУВИЛБАРУУД	32
	ХАВСРАЛТ Б. ОРОЛЦОХ ХҮСЭЛТЭЙ БАЙГАА ЭСЭХИЙГ ТАНДСАН СУДАЛГААНЫ ДҮН	36
	ХАВСРАЛТ В. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МАЯГТЫН ЗАГВАР	40
	ЗӨВХӨН АЛБАНЫ ХЭРЭГЦЭЭНД	40
	ХАВСРАЛТ Г. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	41

I. ТАНИЛЦУУЛГА

1. Аймаг, сумын төвийн ногоон, дасан зохицох чадвартай, бүсийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСБХХОХ) нь сонгогдсон аймгийн төвүүдийн гэр хорооллын хөгжилд зориулсан эрэлт дээр суурилсан, сайн дурын оролцооны аргыг хэрэгжүүлэх юм. Гэр хорооллын хөгжлийн Сайн Дурын Оролцооны Хүрээ (СДОХ) нь гэр хорооллын хөгжлийг дэмжих зарчим, механизмуудыг тайлбарласан баримт бичиг болно. Одоогийн байдлаар хотын үндсэн дэд бүтэцгүй¹, шаардлага хангахуйц гудамжгүй² гэр хорооллыг аймгийн төвийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн гудамж, гудамжаар хөгжүүлэх юм. Загвар гудамжны гэр хорооллын газар өмчлөгч, оршин суугчдын сайн дурын оролцоон дээр тулгуурласан АСБХХОХ нь хотын дэд бүтэц, шаардлага хангахуйц гудамж хөгжүүлэлтээр дамжуулан хотын үйлчилгээг хүртээмжтэй болгож, илүү сайн амьдрах орчинг бий болгоно. Загвар гудамжны газар өмчлөгч, оршин суугчид оролцох хүсэлтэй тохиолдолд л хотын дэд бүтэц, үйлчилгээнд холбогдох, шаардлага хангахуйц гудамжийг хөгжүүлэх боломжтой юм.

2. СДОХ-г Монгол улсын Засгийн газар (МУЗГ) болон АБХ харилцан хүлээн зөвшөөрсөн бөгөөд гэр хорооллын загвар гудамж хөгжүүлэх суурь баримт бичиг болно. Уг баримт бичигт (i) АСБХХОХ болон гэр хорооллын загвар гудамж, (ii) гэр хорооллыг хөгжүүлэх зарчим, механизм; (iii) хэлэлцүүлэг, оролцоо; (iv) хэрэгжүүлэх арга хэмжээ; (v) чадавхийг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр; (vi) хэрэгжүүлэх хуваарь; (vii) аймгуудад гэр хорооллыг хөгжүүлэх загвар туршилтын ажлыг хэрэгжүүлэхэд мөрдөх хяналт-шинжилгээ, тайлагнах талаар мэдээллүүдийг багтаасан болно. Энэхүү СДОХ-нд тусгагдсан зарчим, журамд үндэслэн аймгийн төвүүдэд хэрэгжүүлэх гудамжны төслийн дэд төсөл бүрт сайн дурын оролцооны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

A. АСБХХОХ-ийн мэдээлэл

3. АСБХХОХ нь тогтвортой хот төлөвлөлт, нүүрстөрөгч багатай, дасан зохицох чадвар бүхий бэлчээрийн менежмент болон ногоон агробизнесийн үнийн сүлжээний дэмжлэгийг Монгол Улсад зориулсан нэгдсэн ногоон, дасан зохицох чадвартай агро бүс нутгийн хөгжлийн хүрээнд нэгтгэсэн цогц хөтөлбөр юм. Уг баримт бичиг нь одоо байгаа санаачлагууд дээр үндэслэн суурь парадигмын өөрчлөлт, хүн амьдарч болох суурин газрууд (сум, аймгийн төвүүд) ногоон агро-эдийн засгийн төрөлжилтийн төв болсон, бэлчээрийн гарц муудах явдлыг өөрчлөх боломжтой, хөрсний нүүрстөрөгчийн тусгаарлалтыг хамгийн дээд цэгт нь байлгаж, газар тариалангийн бүтээмж, эдийн засгийн өрсөлдөх чадвар, малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлсэн ногоон хот-хөдөөгийн уялдаа холбоог үүсгэх загварыг дэмждэг. Хөтөлбөр Монгол улсын Засгийн Газрын нутаг дэвсгэрийн бүтээн байгуулалтыг тэнцвэржүүлэх, ногоон эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, тогтвортой бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах, хөдөө орон нутгаас голчлон Монгол улсын нийслэл, Улаанбаатар хот руу шилжин суурьших хөдөлгөөнийг өөрчлөхөд чиглэсэн хот суурин газрын сонирхол татах байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг дэмжих юм. Төсөл дараах 4 зорилттой.

¹ Одоогийн байдлаар аймгийн төвийн гэр хорооллууд зөвхөн цахилгаан болон ундны усыг нийтийн болон хувийн худагаас эсвэл хашаан дах худагнаас авдаг ба халаалт, ариутгах татуурга гэх мэт үйлчилгээ байхгүй болно.

² Гэр хорооллын гудамжууд авто зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн газаргүй. Эдгээр гудамжуудыг шаардлагатай бүх дэд бүтэц, байгууламж бүхий гудамж болгон хөгжүүлнэ.

- (i) **Уур амьсгалд дасан зохицох чадвартай, нүүрстөрөгч багатай, үзэмжтэй аймаг, сумын төвүүдийг хөгжүүлэх:** Зорилтот аймаг, сумын төвүүдийг илүү дасан зохицох чадвартай, илүү дээр амьдрах нөхцөл санал болгосон, ногоон, бүхнийг хамарсан агробизнесийн үнийн сүлжээг хөгжүүлэхийг дэмждэг болгох;
- (ii) **Уур амьсгалд дасан зохицох чадвартай, нүүрстөрөгчийн тусгаарлалт өндөртэй, тогтвортой мал маллахад зориулан бэлчээрийг удирдах:** илүү эрүүл мал, малаасаа илүү өндөр чанартай түүхий эд бэлтгэж, илүү их орлоготой болох малчдын дэмжлэгтэйгээр бэлчээрийн дасан зохицох чадварыг сайжруулах;
- (iii) **Хүртээмжтэй санхүүжилтээр дамжуулан ногоон, олныг хамарсан агробизнесийн үнийн сүлжээг бэхжүүлэх:** дахин бэхжүүлсэн малын агробизнесийн салбар нь тогтвортой бэлчээрийн менежмент, хот-хөдөөгийн уялдаа холбоо, эдийн засгийн төрөлжилтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг малчид болон агробизнесүүдэд зээл өгөх (санхүүгийн зуучлалын зээл [СЗЗ]-ийн бүрэлдэхүүн хэсэг) хувийн салбарын нэмэлт хөрөнгө оруулалтыг татах холимог санхүүжилтээр дасжуулан илүү бага нүүрстөрөгч ялгаруулж, илүү дасан зохицох чадвартай болох;
- (iv) **Ногоон нутаг дэвсгэрийн бүтээн байгуулалтын чадавхи суулгах, бодлого боловсруулахыг сайжруулах:** тохирох сургалт, техникийн зөвлөгөө болон гүйлгээний дэмжлэгээр дамжуулан хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх.

В. Төсөл 1, 1-р шат

4. ОШСЗШ-ын 1-р шатны санхүүжих Төсөл 1 нь баруун бүсийн 3 аймаг дээр төвлөрөх болно (Увс, Ховд, Баян-Өлгий). Зорилт 1-ийн үйл ажиллагаа нь Баян-Өлгий аймгийн Өлгий, Улаангом болон Увс аймгийн Өмнөговь сумдын сум дундын төвүүд дээр төвлөрөх юм. Зорилт 2, 3 нь холбогдох бусад сумдыг хамрана (дээрх аймгуудын эсвэл сум дундын төвүүдийн нөлөөллийн бүст орших сумд). 2,3-р шатны санхүүжүүлэх Төсөл 2, 3 нь Увс аймаг дахь нэмэлт нэг сум (Баруунтуруун гэх мэт), Ховд аймаг дахь 2 сумд (Зэрэг/Дарви болон Булган)-ыг дэмжсэнээр Төсөл 1-ийн зорилтот аймгуудыг дуусгах юм. Шатлал 2 нь хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг, механизмын хэрэгжилтийг тогтвортой бэлчээрийн менежментийн ижил төстэй хөтөлбөрийн үр өгөөж хүртсэн хэсгүүдэд турших болно. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зорилтыг хэрэгжүүлдэг Ховд аймгийн өмнөд хэсэгт байгаль орчны менежмент, агробизнесийн хөгжил, хот байгуулалтын үйлчилгээний хоорондын зөрүүг арилгахаар тохируулсан болно. Шатлал 3 нь Шатлал 1, 2-р бүс нутагт үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх бөгөөд хөтөлбөрийн хандлагад нийцсэн бусад бүс нутагт өргөжиж, бэлчээрийн тогтвортой менежмент, ногоон агробизнесийн хөгжлийн шалгуурт нийцнэ.

С. Аймгуудад гэр хорооллын загвар гудамжийг хөгжүүлэх

1. Хураангуй

5. Гэр хорооллын хөгжил нь АСБХХОХ-ийн төвлөрсөн хотын үйл ажиллагааны цөм нь юм. Эдгээр хөгжил муутай газруудад дэд бүтэц, нийтийн барилга байгууламж, үйлчилгээний хомсдол, орон сууцны барилга байгууламжийн маш муу нөхцөл байдалтай холбоотой асуудлууд голчлон урган гардаг. Үнэндээ гэр хорооллоос гаралтай хотын барилга байгууламж нь хот байгуулалтын хувьд эсрэг үр дүн авчирдаг. Энэхүү хотжилтын горимоос үүдэлтэй хүн амын хэт сул нягтрал нь санхүүгийн бодит бэрхшээл юм. Энэ нь одоогийн нөхцөлд 40хүн/га-ийн хүн амын нягтралтай үед өрх бүрт 37.5 сая төгрөг буюу 14,000 ам.

доллараас 20хүн/га³-ийн хүн амын нягтралтай үед 75 сая төгрөг буюу 28,000 ам. доллар хүртэлх хөрөнгө оруулалт хийх боломжтой барилга байгууламжийн сүлжээг хэрэгжүүлэхэд аюул учруулж байна. Төлөвлөлтийн үеэр гэр хороололд гардаг хүндрэлүүдийг зураг дээр харуулснаар дэд бүтцийн сүлжээнд тохирох санхүүгийн хөрөнгө оруулалтыг тооцсон хамгийн бага нягтрал нь 60 хүн/га-аас дээш байна. Хамгийн оновчтой нягтаршил нь 90хүн/га орчим байна.

6. Хот суурин газрын суурь үйлчилгээ байхгүйгээс гадна оршин суугчид агаар, хөрс, усны бохирдол ихтэй байгаа тул энэ бүтээн байгуулалт маш их хүлээлттэй байгаа. Хэдийгээр салхи ихтэй нөхцө байдлаас шалтгаалан зарим газарт харьцангуй бага нөлөө үзүүлдэг ч эхнийх нь зуух бүрт нүүрс эсвэл илчлэг багатай бусад түлш шатаахаас үүдэн бүхэл бүтэн хот руу заналхийлж байна. Халаалтын сүлжээнд холбогдохыг хүн бүр сонирхдог. Нөгөө талаар усны эх үүсвэр (ихэвчлэн худаг) болон жорлонгийн ойролцоо байгаа хөрс, усны бохирдлыг ус, бохир усны сүлжээгээр хангах замаар шийдвэрлэх болно.

7. (i) Шаардлага хангахуйц гудамж, дэд бүтцийн сүлжээний төлөвлөгөө (ii) талбайг хотын үйлчилгээ - дэд бүтцийн сүлжээнд холбох холболт, (iii) холбогдох техникийн нэгжийг⁴ байгуулах нь газар чөлөөлөх, газрыг дахин хуваарилахад хүргэдэг тул гэр хорооллыг, ялангуяа 1-р шатны загвар гудамжуудыг зохих ёсоор шинэчлэх нь оршин суугчдын амьдралд чухал өөрчлөлтүүдийг авчирна гэсэн үг.

8. Гэсэн хэдий ч, хотын бүрэлдэхүүн хэсгийн гэр хорооллын хөгжлийг хүлээж авах, үр өгөөжөө өгөх нь газар өмчлөгчид болон оршин суугчдын төсөлд сайн дураараа оролцох оролцооноос хамаарна. Энэ нь (i) оршин суугчид оролцох, оролцохгүйгээ бие даан шийдвэрлэнэ, (ii) төслийн загварыг гаргахад оролцох, бөгөөд (iii) нийгэм, эдийн засгийн судалгааны дүн болон төслөөс хүлээж буй үр дүн, нөгөө талаас төслийн хэрэгжилтийг хязгаарлах асуудлыг хэлэлцсэн дараах фокус группийн ярилцлагын үр дүн дээр тулгуурлан төслийг боловсруулах юм. Төслөөр баруун гурван аймгийн төвүүд дэх гэр хорооллын нийт хүн амын 35-аас доошгүй хувийг хамран ажиллах зорилготой бөгөөд гэр хороололд амьдардаг 17,000 өрхөөс⁵ АСБХХОХ-ийн хүрээнд 5,600 орчим өрхийг хамран ажиллана гэсэн үг юм.

2. 1-р шатны загвар туршилтын гудамжийг сонгох

9. Эхний шат амжилттай хэрэгжих нь дараагийн шатнуудын найдвартай байдалд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс зорилтот гэр хорооллын периметр нь төслийн хэрэгжилтийг хялбаршуулахаар хамгийн таатай нөхцлийг бүрдүүлж өгөх ёстой. Юу юунаас илүү доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Одоо байгаа орон сууцны нэгжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүйгээр нягтарших чөлөөт орон зайг үлдээсэн хэт нягт биш барилгын орчин;
- Байгууламжийн өргөтгөлийн зардлыг бууруулах зорилгоор одоо байгаа анхдагч-хоёрдогч сүлжээнд ойр байршил;
- Газрын дахин хуваарилалт, болон нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой аливаа хүндрэлээс зайлсхийх үүднээс үйлчилгээний өргөн өргөн зам.

³ Голын өмнөд хэсгээр 80хүн/га хүрдэг Өлгийг эс тооцон

⁴ “Е” бүлгийг харна уу

⁵ 3 аймгийн төвийн нийт хүн ам: 92,800хүн (NSO 2017) = ойролцоогоор 24,000 өрх – >70% гэр хороололд = 17,000 өрх.

10. Хотын хөгжлийн мастер төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дээрх урьдчилсан шаардлагыг харгалзан гэр хорооллын периметрууд, загвар гудамжуудыг орон нутгийн засаг захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр сонгосон. Мөн дараагийн шатанд хөгжүүлэх шаардлагатай тус бүр нь 800м урт, 40 орчим га талбайн хэсэг болох “загвар гудамж” дээр ажиллана. Эхний шат нь аймаг тус бүрт нэг загвар гудамж, загвар туршилтын эхний замыг хэрэгжүүлсэн үр дүнгээс шалтгаалан боломжтой бол 2 нэмэлт зам барихаар зорьж ажиллана. Тиймээс 1-р шатанд 1,599 хүнтэй 409 өрхийг хамарсан 2,400м 258 хашааг хөгжүүлэх ажил хийгдэнэ⁶.

11. Увс аймгийн Улаангом хотод загвар гэр хорооллын периметр нь 4-р багийн нутаг дэвсгэрийн 31 га байна. Загвар туршилтын гудамж нь хойноосоо урагшаа сунасан 98 хашаа байна. Туршилтын үе шатны нийт талбай нь 8.6 га талбайг хамрана. 1-р зургийг харна уу. Зүүн талын зураг дээрх цагаан шугамууд 31 га периметрийн хил заагийг, шар өнгөөр тодруулсан талбайнууд нь загвар гудамжийг илтгэнэ.


Figure 1 -УВС АЙМГИЙН УЛААНГОМ ХОТЫН ЗАГВАР ТУРШИЛТЫН ГУДАМЖ



12. Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 13 дугаар багийн нутаг дэвсгэрт туршиж буй гэр хорооллын периметр нь 13 га газарт байдаг. Загвар гудамж нь зүүн-баруун хэвтээ тэнхлэгийн дагуу байрлах 87 хашааг хамрана. Туршилтын үе шатны нийт талбай нь 6.8 га. Доорхи Зураг 2-г харна уу. Зүүн дээд талын зураг дээрх гадна талын цагаан шугамууд 33 га периметрийн хил хязгаарыг дүрсэлсэн бөгөөд шар өнгөөр тодруулсан талбайнууд нь загвар гудамжийг илтгэнэ.


⁶ Эдгээр тоо баримт нь санал асуулгын 2 дахь тойргийн дүн юм. 9-р сар/10-р сар 2019.

Figure 2 -БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ ХОТЫН ЗАГВАР ТУРШИЛТЫН ГУДАМЖ



13. Ховд аймгийн Жаргалант хотод туршилтын гэр хорооллын периметрийн хэмжээ нь Тахилт - Алагтолгой багт байрлах 79 га байна. Загвар гудамж нь хойд урд тэнхлэгийн дагуу 72 хашааг нэгтгэсэн. Туршилтын үе шатны нийт талбай нь 12.3 га. Зураг 3-ыг харна уу. Гаднах улаан цэгүүд 79 га периметрийн хил хязгаарыг дүрсэлсэн бөгөөд шар өнгөөр тодруулсан талбайнууд нь загвар гудамжийг илтгэнэ.

Figure 3 -ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ ХОТЫН ЗАГВАР ТУРШИЛТЫН ГУДАМЖ



II. ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, МЕХАНИЗМ

A. Зорилт

14. Гэр хорооллын хөгжлийн зарчим нь 3 үндсэн зорилтыг биелүүлэхийг зорьж байна. Үүнд:

- Эхний зорилт бол нэг сүлжээний шугамаас, өөрөөр хэлбэл загвар туршилтын гудамжнаас аль болох олон хашааг үр өгөөжөө өгөх, аль болох олон хашааг⁷ дэд бүтцийн сүлжээнд холбох;
- Хоёрдахь зорилт нь холбогдсон байшинд хуучин байшин эсвэл шинэ орон сууцны хороололд холболт хийх боломжийг олгодог техникийн байрыг хэрэгжүүлэх; Энэхүү техникийн байрны өртгийг нөхөхийн тулд газар өмчлөгч нь газрынхаа зах зээлийн үнээс хамааран өөрийн хашааны зарим хэсгийг өгөх ёстой;
- Гурав дахь зорилго нь загвар зам болон хотын үйлчилгээний сүлжээг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг зөвтгөх шаардлагатай нягтралаар дамжуулан өмнөх ажлуудыг нөхөж байна: замын дагуух хүн амын нягтрал дор хаяж 90хүн/га хүртэл нэмэгдэх ёстой бөгөөд энэ нь хувь хэмжээ юм. Хямд үнэтэй орон сууцны хорооллын барилгын ажил дууссаны дараа: холболтууд илүү их байх тусам санхүүгийн үр ашиг, ашиг өндөр байх болно.

15. Гэр хорооллыг хөгжүүлэх зарчим, механизмыг ашиг хүртэгч өрхүүдийн оролцоо нь зөвхөн сайн дурын үйл явц байх бөгөөд албадлагын оролцоо байхгүй болно гэсэн үндсэн зарчимд үндэслэнэ. Хэлэлцээрийг эцэслэхээс өмнө аль ч хүн, өрх оролцох хүсэлгүй байвал өрхөөс зайлсхийх болно.

B. Монгол Улсын хууль ба дүрэм

16. АСБХХОХ-ийн хүрээнд гэр хорооллыг хөгжүүлэх асуудлаар Монгол Улсын Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулинд хууль эрхзүйн үндсэн хүрээ, хэрэгжүүлэх журмыг тусгасан болно. Энэ хуулийн зорилт нь: (i) хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, (ii) ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, (iii) гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. Уг хуульд дахин төлөвлөлтийн ажилд төрийн байгууллага, газар өмчлөгч, хувийн хэвшил зэрэг холбогдох талуудын үүрэг, хариуцлага, хотын дахин төлөвлөлтийн ажилд хэрэгжүүлэх алхам, журмыг тусгасан болно. Энэхүү хуулийн дараагаар Монгол Улсын Засгийн газар (i) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам⁸, (ii) Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмыг⁹ боловсруулан баталсан. Гэр хорооллын загвар гудамжийг хөгжүүлэхэд эдгээр хууль тогтоомжийг мөрдөнө.

⁷ Хашаа – мод, шавар тоосгоор хил заагийг тогтоосон гэр хорооллын газрын нэгж. Хашаанд ихэвчлэн байшин эсвэл гэр байдаг.

⁸ МУЗГ-аас 2018.11-р сард баталсан, ЗГ-ын 2018 оны 341 тоот тогтоол.

⁹ МУЗГ-аас 2018.3-р сард баталсан, ЗГ-ын 2018 оны 46 тоот тогтоол.

С. Гэр хорооллын хөгжлийг хэрэгжүүлэх гол алхмууд

17. Уг арга барилыг доорх 6 алхмаар хураангуйлав. Үүнд:

- **1-р алхам** – Загвар туршилтын гудамжийг тодорхойлох, түүний зохион байгуулалтыг гэр хорооллын хөгжлийн өргөн хүрээтэй хийх эхний алхам гэж ойлгох хэрэгтэй;
- **2-р алхам** - Холбоотой сүлжээнүүдтэй зам засварын ажил. Дараах сүлжээ бүхий хатуу хучилттай зам; усан хангамж - ариутгах татуурга - халаалт - цахилгаан - харилцаа холбоо - гудамжны гэрэлтүүлэг;
- **3-р алхам** - Газар өмчлөгчид болон оршин суугчдын хүсэл, хүлээлтийн дагуу хашааг сүлжээнд холбох;
- **4-р алхам** – Ариун цэврийн болон халаалтын хүссэн шинж чанарыг цуглуулдаг техникийн нэгж (ТН) гэж нэрлэгдэх техникийн байгууламжийг барьж байгуулах, ТН-ин талаархи ойлголт, хувилбаруудыг Хавсралт А-аас үзнэ үү;
- **5-р алхам** - Төрийн орон сууцны корпораци - ТОСК гэх мэт нийтийн хөгжүүлэгч ажиллуулж болох нягтаршилт;
- **6-р алхам** - (i) Авто замын зураг төсөл, (ii) ТН-ээр солин шилжүүлж буй газрыг буулгахаас үүсэх талбайг дахин хуваарилах, нягтруулах процесс эсвэл нийтийн болон хувийн зорилгоор ашиглах; Хэрэв газрыг ТОСК-д шилжүүлээгүй бол түүнийг нутгийн захиргааны газрын эзэмшил газар болгож, ашиглалтын асуудлыг шийдвэрлэнэ: нийтийн тохилог байдал, хотын байгууламж, хувийн хөгжүүлэгч рүү худалдах, газар түрээслэх замаар хувийн хот хөдөө аж ахуй гэх мэт. Энэхүү цэглэсэн газрын хувьд төслийн санхүүжилтээр тоглоомын талбай болон олон нийтийн төвийн барилгын ажилд зориулагдсан болно.

18. Газар эзэмшигч болон оршин суугчид тохиролцоонд хүрэх, газраа чөлөөлж өгөхөөс өмнө төлөвлөсөн зүйлсийн талаар мэдээллийг тэдэнд өгдөг. Энэхүү мэдээлэл нь туршилтын хөгжлийн үе шат гэж тодорхойлсон гудамжны дагуу амьдардаг бүх өрхөд чиглэсэн фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ) хэлбэрээр хэд хэдэн тодорхой уулзалтуудад хамрагдах болно. Хөгжлийн эдгээр зарчмуудыг мэдсэнээр газар өмчлөгч болон оршин суугчид төсөлд өөр хэлбэрээр оролцохоор зөвшөөрөх, эсвэл төслийн нөлөөнд орохоос татгалзах гэх мэтээр өөрсдийн сонголтоо чөлөөтэй илэрхийлэх болно. Эдгээр хувилбаруудын талаар мэдэж байгаа эсэх нь судалгааны үр дүнгээс харагдах бөгөөд судалгааны тоон мэдээллийн хэмжээ, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулдаг. Төсөлд хэн ч албадах ёсгүй, оролцоо нь бүхэлдээ сайн дурынх юм.

D. Хэрэгжүүлэх алхмууд


19. Хэрэгжүүлэх алхмуудыг загвар гудамжны дагуу замын нэг талд хоёр (талбай 1, 2), нөгөө талд нь (талбай 3) байрлах дотроо байшинтай гурван хашааны нийтлэг жишээн дээр дүрсэлсэн болно. Зураг 4-ийг үзнэ үү.

20. **2-р алхам** - "Загвар" гудамжийг тодорхойлох ажил (**алхам 1**). Зам, хотын үйлчилгээний сүлжээг хэрэгжүүлэх ажлыг дараахь байдлаар хийнэ. Үүнд:

- Эхний ээлжинд нэг чиглэлийн зам байж болох хатуу хучилттай авто зам, явган хүний/ дугуйн замын хамтаар барих;

- Нэг чиглэлтэй зам бол (i) аюулгүй байдал, (ii) төсвийн хүрээнд боломжийн сонголт юм. Энэ нь хөдөлгөөнт төлөвлөгөөний нэг хэсэг байх ёстой бөгөөд шаардлагатай бол дараа нь өргөжүүлж боломжтой байх: дэвсгэр зураг (нэг чиглэлийн) 10м-ээс (хоёр чиглэлийн) 12м хүртэл;
- Хотын үйлчилгээнүүдийн сүлжээг тэрэгний зам дагуу бус, явган хүний зам дагуу хийх;
- Явган хүний/дугуйн эгнээний арын хэсэгт нэвтрэх боломжтой; автомашинаар нэвтрэх эрэлт байгаа бол зурвас газрыг хашаа 2-т ногдуулж болно.

Figure 4 -2,3-Р АЛХАМ



21. **3-р алхам** – Траншейны нүхнээс эхлэх холболтын цэгийг оршин суугчид нь шийднэ: 1 байшингийн ойролцоо 1-р талбай, газар эзэмшигчийн өөрийнх нь төлөвлөгөөний дагуу талбайд 3-ыг байрлуулна.

- Холболтын үйлчилгээний нүхний оновчтой байршлыг инженерийн баг урьдаар шийддэг;
- Талбай 2-ын хувьд хөгжүүлэгчийн удирдаж буй нягтруулах төсөлд зориулж нэг хэсэг газрыг өгсөн. Одоо байгаа нэг барилгын ажлыг буулгах ёстой;
- Дараах алхамаар шаардагдах газар олголтыг (ТН хуваарилах) хоёр аргаар удирдаж болно. (i) ТУ-тай “тэнцэх” газрыг тэр даруй газар эзэмшигчид буцааж өгдөг. Энэ бол хамгийн нийтлэг механизм юм. (ii) онцгой тохиолдолд, жишээлбэл, нэг талбай нь дор хаяж 2 ТУ-тэй тэнцэх газрын гадаргууг буцааж өгдөг бөгөөд энэ нь эцсийн эцэст газар өөрчлөгдөхөд хүргэдэг.

22. **Алхам 4** – Хашаа бүр хашаан доторх байр байшингийн төрөл, талбай дээрх байршил, тоног төхөөрөмжийн түвшин, тоног төхөөрөмжийн чанар зэргээс хамааран өөр өөр байдаг. Тиймээс одоо байгаа байшинд шууд холболт хийхэд норм, стандартыг дагаж мөрдөх гэвэл бараг боломжгүй юм. Тийм ч учраас холболт, орон сууцны хоорондох уялдаа холбоог хангахын тулд "техникийн нэгж" нь нэн чухал юм. ТН-ийн үүргийг дараах байдлаар нэгтгэв.

- ТН нь хөлдөх эрсдэлээс сэргийлсэн шүршүүр, угаалтуур, ус, радиатор зэргээс бүрдэнэ. Өмчлөгч нь нэгээс дээш ТН авах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд нэмэлт газрыг чөлөөлөх шаардлагатай болно;
- Хашаанд байрлах газар нь хязгаарлагдахгүй: 1-р талбайд гал тогооны өрөөнд өргөтгөл хийх боломжтой доторх ариун цэврийн байгууламжийг ашиглахын тулд одоо байгаа байшинд нэгдэхээр шийдсэн; эсрэгээр 3-р байр, өөр байшинд байрлуулахыг илүүд үздэг бөгөөд энэ нь өмчлөгч өөр байшинд нэгдэхээр төлөвлөж байгаа тохиолдолд тохиролцож болно.
- Одоо байгаа эсвэл төлөвлөсөн орон сууцны барилга байгууламжтай ямар ч холбоогүй ТН-ийн байршуулахыг зөвшөөрөхгүй;
- Үүнээс гадна ТН-ийг хүлээн авагч нь одоо байгаа байшингийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, эсвэл тусгаарлагдсан шинэ орон сууц барих шаардлагатай;
- ТН-ийн хэрэгжилт нь энэхүү сайжруулалтаас салшгүй холбоотой гэсэн үг; хоёулаа бүхэл бүтэн нэгдмэл байдлаар тооцогдох ёстой;
- Энэхүү зорилгын үүднээс түүний эзэн тодорхой материалын үнэд тохирсон “ваучер” авах болно;
- Архитектор / инженерийг ажлын зөвлөх, хянагчаар томилно.





Figure 5 — 4-р АЛХАМ

23. **5-р алхам** - 2-р талбайд нийтийн хөгжүүлэгч (ТОСК) нь 25м өргөнтэй талбайд, хамгийн дээд тал нь 3 давхар хоёр таунхаус барих зэргээр нягтралаа эхлүүлнэ.

- Таунхаус тус бүр нэг нэг “бүрхүүл ба цөм” орон сууцнаас бүрдэнэ (нэг орон сууцанд 50 м2 ба түүнээс дээш, доош).
- “Бүрхүүл ба цөм” гэдэг нь тухайн бүтээн байгуулалтын ажил үндсэн ажлыг гүйцэтгэж дуусахаас өмнө зарах гэсэн үг юм. Уран зураг, хавтанцар, сантехник, цахилгаан хэрэгслийг худалдан авагч хариуцдаг. Хоолой ба цахилгаан утас, самбарыг хөгжүүлэгч хийдэг;

- Үүний дагуу борлуулах үнэ боломжийн хэвээр байгаа бөгөөд барилгын үнээс хамааран хамгийн ихдээ 1 м2 тутамд 9,000,000 төгрөг байх бөгөөд үүнийг нарийвчлан боловсруулахад бага зэрэг төвөгтэй болно;
- Банкны нөхцөл байдлыг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулна; гэсэн хэдий ч, түрээслэгч өөрөө түрээслэх замаар орон сууцыг авах боломжтой;
- Хөгжүүлэгч нь түрээслэхээр төлөвлөж буй орон сууц, нийгмийн орон сууцны 10 орчим хувийг юуны түрүүнд газар өмчлөгчид, эцсийн байдлаар нүүлгэн шилжүүлсэн айлуудад зориулан төлөвлөх ёстой; зарим орон сууц нь хүмүүст зориулагдсан байдаг;
- The Norm BnDB23-03-09-тай холбоотой эрчим хүчний үр ашгийн асуудлыг нарны хавтанг суурилуулах замаар бэхжүүлсэн дулаалга болон нэмэлт эрчим хүчний эх үүсвэрийг авч үзэх болно. 3-р талбар дээр газар өмчлөгч нь худалдах, түрээслэх зорилгоор хувийн хэрэгцээнд зориулж хашааг өөрөө боловсруулдаг. Энэ нь нягтруулах ажилд бас оролцдог. Энэ хашааны өөр нэг хувилбар нь төсөл дэх ямар ч оролцоогүй, холболтгүй, техникийн нэгж байхгүй, хувь хүний хөгжилд татгалзах явдал юм (сонголт 1).

Figure 6 -5-P АЛХАМ




24. 6-р алхам - Төгсгөлд нь 2-р талбайд газрыг дахин тохируулах шаардлагатай болох магадлалтай. Хоёр сонголт байна. Үүнд:

- 2-р талбайд дахин газар шаардлагагүй бөгөөд үлдсэн талбайд өмчлөгч сэтгэл ханамжтай байх; өмчлөгчид ТН, дахин нэг ТН авах хүсэлтэй бөгөөд чөлөөлсөн газар нь шаардлагад нийцсэн бол + дахин нэг ТН эсвэл барилга барих зориулалттай газартай тэнцэх эрхийн бичиг;
- Эсвэл газар эзэмшигчид нөхөн төлбөр өгөхийг хүсч байгаа бөгөөд хоёр талбайн гадаргууг тэнцвэржүүлэх үүднээс 1-р талбайтай тохиролцоонд хүрэх. Энэ тохиолдолд 1-р талбай нь ТН-тэй тэнцэх газрын хэсгийг буцааж өгнө.
- Нийтийн хөгжүүлэгч нь гарааш, дэлгүүр гэх мэт нэмэлт байгууламж бүхий хотхоны барилгыг өргөтгөж болно. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд төслөөс гадуур үлддэг.

Тэдний үндэслэл, санхүүжилт нь хөгжүүлэгч өөрөө хийсэн зах зээлийн зохих судалгааны үр дүнд бий болно.

Figure 7 -6-P АЛХАМ



Е. Газар өмчлөгчдөд олгох сонголтууд

25. Оршин суугчдад дараахи 3 сонголтыг санал болгоно. Үүнд:

- **Сонголт 1** – хөтөлбөрт оролцохгүй байх:
 - талбай нь бүтээн байгуулалтад нөлөөлөөгүй бөгөөд энэ үр дүн нь эзэмшигчийн хүсэлд нийцдэг;
 - эсвэл эзэмшигч нь хөгжүүлэлтэд оролцохоос татгалзсан;
 - Ямар ч тохиолдолд эзэмшигч нь өөрөө бүрэн төлсөн техникийн нэгжтэй холбогдохыг хүсч болно (нэг м тутамд 1,3 сая төгрөг, техникийн нэгжид 8,5 сая төгрөг).
- **Сонголт 2** – Төсөлтэй холбоотой аливаа зорилгоор газраа хэсэгчлэн чөлөөлөхөд холболт + ТН-ийн зардал дээр хямдрал үзүүлэх гэх мэт нөхөн олговор авах эрхтэй болно. Дараахийг санах хэрэгтэй.
 - Нэмэлт ТН шаардах боломжтой; чөлөөлсөн газрын хэсэг нь хүссэн ТН-ийн тоотой таарч байх ёстой;
 - Хэрэв газар нь нэг ТН-д шаардагдах талбайн хэмжээнээс давсан тохиолдолд газар эзэмшигчид барилгын материалыг худалдан авах эрхийн бичиг олгох гэх мэтээр нөхөн олговрыг авах эрхтэй;
 - Хэрэв өмчлөгч орон сууц худалдаж авахыг хүсвэл орон сууцнаас чөлөөлсөн газартайгаа тэнцэх метр квадратыг нь нөхөн олговроор авч

болно: зах зээлийн үнээр орон сууцны нэг метр квадрат нь ойролцоогоор 60 метр квадрат газартай тэнцэнэ.

- **Сонголт 3** – Эзэмшигч нь хашааг бүхэлд нь өгөхийг хүссэн тохиолдолд Сонголт 2-г 2-р хувилбар юм. энэ нь илүү их нөхөн олговрыг хүргэх ёстой боловч үүнтэй төстэй байдлаар удирддаг; гэхдээ энэ нь 2-р сонголтыг дэмждэг төслийн зорилго биш юм; хэрэв ийм сонголтыг онцгой тохиолдолд зайлшгүй хийх боломжгүй бөгөөд хэрэв энэ нь сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт хийхгүй бол эзэмшигч нь уг төсөлд хамрагдсан байшингийн үнэ цэнэтэй тэнцэх талбай бүхий орон сууцны байшинд хамрагдах боломжтой болно.

26. Шинээр баригдах орон сууцанд нь загвар туршилтын гудамжинд оршин суугчид нэн түрүүнд орох эрхтэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Орлогынхоо дагуу тэд шууд үнийг нь төлж худалдан авах, моргежийн 8% зээлээр, урьдчилгаа төлбөрийг 20-30%-г хийж, жишээлбэл 20 жилийн хугацаанд зээлээ төлөх нөхцлөөр авах, эсвэл байшингаа түрээслээд өмчлөх хэлбэрээр худалдан авах, эсвэл түрээслэн суух эсэхээ шийдэх ёстой.

Г. Газар эзэмших эрхгүй газар эзэмшигчид олгох сонголт

27. Газар эзэмших эрхгүй иргэдэд дараахь сонголтууд байна.

- **Сонголт 1** – газар дээр үлдэх:
 - Судалгаа болон Фокус Группын Ярилцлагаар хоёрдогч оршин суугчид нь ихэвчлэн газар өмчлөгчийн хамаатан байдаг нь тогтоогдсон бөгөөд 250 м2 газрыг чөлөөлөхөд тэд нүүх шаардлагагүй болно;
- **Сонголт 2** – нийтийн байранд түрүүлж оруулах:
 - Хоёрдогч өрхөд АБНХХОХ-ийн хүрээнд худалдаж авах, түрээсээр худалдан авах, түрээслэх гэсэн сонголттойгоор ТОСК-ийн барьсан нийтийн байранд түрүүлж оруулах;
 - Орлогын шатлалынхаа дагуу өрхүүд сонгодог худалдан авалт буюу 8%-н зээл, урьдчилгаа 20%-30%-ийг төлөөд 20 жилийн хугацаатай түрээслэх, эсвэл түрээсээр худалдан авах, эсвэл ТОСК-ийн орон сууцны зохион байгуулалт дээр үндэслэн нийтийн түрээслэх энгийн гэрээг хийж болно.

Г. Гэр хороолол хөгжүүлэлтийн нийтлэг хувилбарууд

28. Гэр хорооллын загвар гудамжийг хөгжүүлэхэд боломжит нийтлэг хувилбаруудыг тодорхойлсоныг доод Зураг 8-аас үзнэ үү.


29. Эхний ээлжинд хувилбарууд дараах таамаглалд тулгуурладаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

- Газрын зах зээлийн үнэлгээгээр 250 кв.м нь ТН-ийн бодит өртгийн 30-50% -ийг хамардаг.
 - ТН-ийн бодит үнэ цэнийг нөхөх нэг мкв үнэ 34000 төгрөг байх ёстой
 - Зах зээлийн үнэ самбараас 7000-115000 төгрөг / кв.м.
- Газрыг чөлөөлсөний дараа үлдсэн талбай нь дор хаяж 200м2 байх ёстой бөгөөд хэрэв 250м2-ийг чөлөөлсөн бол хашааны анхны хэмжээ 450м2 байсан гэсэн үг.

- Хэрэв хашаа 450м²-аас их байгаад ТН-ийг 250м² хүрэхгүй газраар сольсон бол, хоёр боломж байна.
 - Газар өмчлөгч зөрүүг төлнө (250м² – чөлөөлсөн газар)
 - Газар өмчлөгч эмзэг бүлгийн хүн бол төлбөр төлөх шаардлагагүй.
- Сонголт 2-ын оршин суугчид замын сүлжээний нүх, траншейны нүхнээс гарах хоолой, ТН хүртэлх холболтуудыг үнэгүй хийж өгнө.
- Эцэст нь оршин суугчид "холболт + ТУ" нийт үнийн дүнгийн 10 орчим хувийг төлдөг.

30. Доорх 8-р зураг нь "хамгийн нийтлэг хувилбарууд" -тай холбоотой зарим тодруулгыг доор үзүүлэв.


Figure 8 -ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХАМГИЙН НИЙТЛЭГ ХУВИЛБАРУУД



СОНГОЛТ 1 – Төсөлд оролцохгүй

Хувилбар 1

Холболт + ТН суулгах хүсэлт оршин суугч гаргасан бол оршин суугч өөрөө төлнө.



СОНГОЛТ 2 – Төсөлд оролцох

	Хувилбар 2 250м2 газраар ТН холбуулах	Хувилбар 4 250м2-аас их газраар ТН холбуулах нэмэлт м2 газарт нөхөн олговор олгох	
	Хувилбар 3 2*250м2 газраар 2 ТН холбуулах	Хувилбар 5 250м2-аас бага газраа чөлөөлөх 1 ТН-ийг худалдан авах (250-S)	
	Хувилбар 6 2 хашааг нийлүүлэн, нийт 250м2 газраар 2 газрын хооронд нэгдсэн ТН холбуулах	Хувилбар 7 - Холболт/ТН байхгүй - Орон сууцны урьдчилгаа төлбөртэй тэнцэх газрыг чөлөөлөх - газар тариалангийн чиглэлээр ашигладаг, барилга барих боломжгүй үлдсэн газар	

31. “Хамгийн нийтлэг хувилбар”-уудтай холбоотой зарим тодруулгыг дор жагсаав.

Сонголт 1:

- Хувилбар 1 – Төсөлд оролцохгүй оршин суугч холболт хийлгэхээс татгалзах эсвэл мөнгө төлөөд ТН холбуулж болно.

Сонголт 2:

- Хувилбар 2 – 250м2 газрыг нэг ТН-ээр солих энгийн солилцоо нь хамгийн нийтлэг хувилбарт тооцогдож байна.
- Хувилбар 3 – Хашаан доторх өрхийн тооноос хамааран, зарим оршин суугч 2 250м2 газрыг 2 ТН-ээр солин авах боломжтой.
- Хувилбар 4 – Хотжуулах үйл явц эсвэл талбай өмчлөгчийн шаардлагатай холбоотой зарим онцгой тохиолдолд талбай өмчлөгч 250м2-аас илүү газрыг чөлөөлөх хүсэлт гаргах боломжтой. Энэ тохиолдолд ТН дээр


нэмээд барилгын материал худалдан авах эрхийн бичиг эсвэл бэлэн мөнгөөр нөхөн олговор авах боломжтой.

- Хувилбар 5 – аливаа шалтгаанаар, тухайлбал, хашаанд үлдээж болохгүй өмч хөрөнгө байгаа тохиолдолд талбай өмчлөгч 250м2 газраа бүтнээр нь чөлөөлөх боломжгүй эсвэл хүсэлгүй бол 250м2 болон чөлөөлсөн газрын зөрүүг худалдан авах ёстой.
- Хувилбар 6 – 2 хашаа нийлээд дундаасаа 250м2 газар чөлөөлөөд 1 ТН авах боломжтой. Тус тусын хөрөнгийг хамгаалах эсвэл хашаанууд дангаараа жижиг хэмжээтэйн улмаас ийнхүү шийдвэрлэх боломжтой.
